



НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 02 сарын 15 өдөр

Дугаар Б/12

Улаанбаатар хот


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын "Төсвийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.5.5 дахь заалтууд, Тус албаны 2013 оны 02 дугаар сарын 05-ны Техникийн комиссийн 10 дугаар тоот актыг тус үндэслэн ТУШААХ нь:

1. Агаарын чанарыг хэмжигч суурин станцын хэвийн үйл ажиллагааг явуулах зорилгоор AQMS явуулын хэмжилтийн станцын хийн анализаторуудын дотор электроникийн эд ангиудын болон гаднаас агаар сорох хийн хоолойн системүүдийн бохирдлыг арилгахад хөрөнгө гаргасугай.

2. Тус AQMS явуулын хэмжилтийн станцын хийн анализатор тус бүрийг задалж бохирдсон эд ангиудыг цэвэрлүүлэх, гаднаас хий сорох хоолойн системийг зориулалтын шингэнээр угаахад гарах нийт зардал болох 1.780.000 /нэг сая долоон зуун наян мянга/ төгрөгийг урсгал засварын зардлаас олгохыг нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.БАТСАЙХАН